






БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2026 он

ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС


д/д	Албан тушаалтан	Шийдвэрлэх санал	Танилцсан
1	Батлан хамгаалахын сайд Д.Батлут		
2	Батлан хамгаалахын дэд сайд Д.Баасандамба	Найрчилго, утгын засвар	
3	Төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал Д.Ганхуяг		
4	Батлан хамгаалахын сайдын зөвлөх Г.Сайханбаяр		
5	Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар	Э-мжсэж.	Ж.Болдбаатар
6	Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга бригадын генерал Ч.Гандирваа		
7	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хурандаа М.Батхуяг		
8	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр	Э-мжсэж.	Б.Мөнхбаяр
9	Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Э.Гансүх		Э.Гансүх
10	Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газрын дарга хурандаа Р.Энхболд		
11	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан		
12	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хурандаа Б.Оюунгэрэл		

д/д	Албан бичгийн агуулга	Тайлбар	Санал
1	БХЯ-ны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Батлан хамгаалах яамны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/124 тушаалаар ажлын хэсгийг байгуулан ажилласан.	

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН:
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

2026 оны 01 дүгээр сарын ...-ны өдөр



Д.БАТЛУТ

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

2026 оны 01 дүгээр сарын ...-ны өдөр

Д.ГАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ, зорилт	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, /2025 он/	Зорилтот түвшин, /хэрэгжих дуусах хугацаа/	Хугацаа улирал (I-IV)	Хариуца х нэгж
1	2	3	4	5	6	7	8
2026 ОН “ХҮН ТӨВТЭЙ ХӨГЖИЛ-ШИНЭЧЛЭЛТ”-ИЙН ЖИЛ							
ЭХ ОРОНЧ ҮЗЭЛД СУУРИЛСАН ХҮН ТӨВТЭЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ, БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛНЭ.							
ЗОРИЛТ 1. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ЦОГЦ БАЙДЛЫГ ХАНГАХ, БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫГ ХӨГЖҮҮЛЖ, УЛСЫН НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.							
1.1	Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомж, цэргийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах	Урсгал зардлын хүрээнд	Боловсруулсан баримт бичгийн тоо	1 хууль, 2 бодлогын баримт бичиг, 2 журам, 5 дүрмийг боловсруулсан.	Хагас жилийн байдлаар: - 1 хууль, 2 журам, 2 дүрэм боловсруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: - 3 хууль, 1 бодлогын баримт бичиг, 2 журам, 5 дүрэм боловсруулсан байна.	I-IV улирал	СБТГ, ТЗУГ, БХЗГ, ОНХДГ
1.2	Монгол Улсын дунд, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд Батлан	-	Боловсруулсан санал, тайлангийн тоо	Санал-2, Тайлан-4	Хагас жилийн байдлаар: -Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд Батлан	I-IV улирал	СБТГ, БХЗГ, СХОХ

1	2	3	4	5	6	7	8
	хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах				хамгаалах чиглэлээр тусгах санал-1; -Монгол Улсын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан-2. Жилийн эцсийн байдлаар: -Монгол Улсын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан-5;		
1.3	Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулахаар Засгийн газарт хүргүүлэх	-	Засгийн газарт хүргүүлж, шийдвэр гаргуулсан байх	Улсын Их Хурлын тогтоол батлагдсан.	Хагас жилийн байдлаар: Төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна.	I, II улирал	БХЗГ
1.4	Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил, арга хэмжээ-12	Хагас жилийн байдлаар: -Судалгаа хөгжүүлэлтийн ажил, арга хэмжээ-8. Жилийн эцсийн байдлаар: -Судалгаа хөгжүүлэлтийн ажил, арга хэмжээ-14.	I-IV улирал	СБТГ, ГХАГ, ЗХЖШ, БХЭШХ, ҮБХИС
1.5	Батлан хамгаалахын "Шинжлэх ухаан, технологи, инновацийн шилдэг бүтээл"-ийг шалгаруулах, шагнаж, урамшуулах, эргэлтэд оруулах журмын хэрэгжилтийг зохион байгуулах	130.0 сая ₮ ЗХХС	Арга хэмжээний бүтээлийн тоо	Арга хэмжээ-2	Хагас жилийн байдлаар: -Шилдэг бүтээлийг шалгаруулах тухай зарыг улс орон даяар нээлттэй зарлана. Жилийн эцсийн байдлаар: - Шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж, 24-30 зохиогч, бүтээгчийг шагнаж, урамшуулна; - Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний эрх ашигт нийцсэн 2-3 бүтээлийг эргэлтэд оруулж,	I-IV улирал	СБТГ, яамны ШУТИЗ болон салбар зөвлөлүүд

1	2	3	4	5	6	7	8
					зохиогч, бүтээгчийг шагнаж, урамшуулна.		
1.6	Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын нисэхийн үйл ажиллагаанд зорилтот үзлэг, шалгалт хийх	-	Зорилтот үзлэг, шалгалтын тоо	8 удаагийн зорилтот үзлэг, шалгалт хийж, актыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Хагас жилийн байдлаар: - Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн байгууллагуудад 3 удаа зорилтот үзлэг, шалгалт хийж, актыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: - Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн байгууллагуудад 6 удаа зорилтот үзлэг, шалгалт хийж, актыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.	I-IV улирал	СБТГ
1.7	Улсын агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварыг тодорхойлж, гэрчилгээ олгох	300,0 мянган төгрөг	Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгосон тоо	8 нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгосон.	Хагас жилийн байдлаар: -Улсын агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын 2 гэрчилгээг олгоно. Жилийн эцсийн байдлаар: -Улсын агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын 5 гэрчилгээг олгоно.	I-IV улирал	СБТГ
1.8	Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний нисэхийн мэргэжлийн үнэмлэхийг олгох, сунгах, зэрэг, зэрэглэл олгох	3.6 сая төгрөг	Нисэхийн мэргэжлийн үнэмлэхийг сунгаж, шинээр олгосон тоо	59 алба хаагчдын нисэхийн мэргэжлийн үнэмлэхийг сунгаж, 8 нисгэгчид нислэг үйлдэх зөвшөөрөл олгосон.	Хагас жилийн байдлаар: -Нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний 8 нисэхийн мэргэжлийн үнэмлэхийг сунгаж, 1 зөвшөөрөл олгоно. Жилийн эцсийн байдлаар: -Нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний 20 нисэхийн мэргэжлийн үнэмлэхийг сунгаж, 1 зөвшөөрөл, 10 зэрэг, 2 зэрэглэл олгоно.	I-IV улирал	СБТГ
1.9	Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хот, хөдөөгийн сэргэлт" бодлогын хүрээнд зарим ангийг нүүлгэн	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Хагас жилийн байдлаар: -Ангийг нүүлгэн шилжүүлэх санал, тооцоо, судалгааг боловсруулна. Жилийн эцсийн байдлаар:	I-IV улирал	СБТГ, БХЗГ, ЗХЖШ

1	2	3	4	5	6	7	8
	шилжүүлэх бэлтгэлийг хангах				-Ангийг нүүлгэн шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоол гаргуулах саналыг хүргүүлнэ.		
1.10	Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн бүтцэд мэргэшсэн бүрэлдэхүүнтэй нэгжийг байгуулах асуудлыг боловсруулах	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	Анхны төсөл боловсруулсан.	Хагас жилийн байдлаар: -Хуурай замын цэргийн бүтцэд шинээр нэгж байгуулах тухай тооцоо, судалгааг дахин боловсруулна. Жилийн эцсийн байдлаар: -Хуурай замын цэргийн бүтцэд шинээр нэгж байгуулах асуудлыг Засгийн газарт хүргүүлнэ.	I-IV улирал	СБТГ, ЗХЖШ
1.11	Батлан хамгаалахын сайдын нэрэмжит "Бэлэн байдлын үзлэг"-ийг зохион байгуулах	-	Үзлэг зохион байгуулсан нэгтгэл, ангийн тоо	2025 онд Зэвсэгт хүчинд "Бэлэн үзлэг" явагдсан.	Хагас жилийн байдлаар: Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжийг боловсруулж батлуулна. Жилийн эцсийн байдлаар: "Бэлэн байдлын үзлэг"-ийг харьяа 1-2 анги, байгууллагуудад зохион байгуулсан байна.	I-IV улирал	СБТГ, ЕХШАА, ЗХЖШ
ЗОРИЛТ 2. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, САЛБАРЫН ЦАХИМЖИЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АЛБА ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ ХҮН ТӨВТЭЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
2.1	Батлан хамгаалахын хүний нөөцтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх	-	Хүний нөөцтэй холбоотой шийдвэрлэсэн асуудлын тоо	Удирдах, гүйцэтгэх 208 албан тушаалтныг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилуулан, харьяа байгууллагаас 83 ЦАХ-ийн чөлөөлж, шилжүүлсэн.	Хагас жилийн байдлаар: -Хэрэгцээг тодорхойлж сул орон тоог нөхөн хангасан байна. -Нийт албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийсэн байна. Жилийн эцсийн байдлаар: -Хүний нөөцийн орон тоог тухай бүр бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу томилох асуудлыг шийдвэрлэсэн байна.	I-IV улирал	ТЗУГ
2.2	Төрийн зөвлөлийн албаны салбар	-	Салбар зөвлөлийн хуралдааны	Салбар зөвлөлийн хуралдааныг 8 удаа	Хагас жил, жилийн эцсийн байдлаар:	I-IV улирал	ТЗУГ

1	2	3	4	5	6	7	8
	зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах		шийдвэрлэсэн асуудлын тоо	зохион байгуулж, тайланг 1 удаа ТАЗ-д хүргүүлсэн.	-Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянасан дүгнэлт"-ийг яамны цахим хуудсанд байршуулж, ил тод байдлыг хангана. -Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж, салбар зөвлөлийн хуралдааныг 10 удаа хуралдуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.		
2.3	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авч бүртгэх, шийдвэрлэх	-	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хувь	2025 онд 7393 иргэд, аж ахуйн нэгжийн өргөдлийг 96 хувьтай шийдвэрлэсэн.	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: -Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авч бүртгэх, шийдвэрлэх, хяналт тавих, шийдвэрлэлтийн мэдээ тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийнэ. -Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэнэ.	I-IV улирал	ТЗУГ
2.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 85% байна.	Хагас жилийн байдлаар: -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан байна. -Салбар зөвлөлийг хуралдуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хангана.	I-IV улирал	ТЗУГ

1	2	3	4	5	6	7	8
2.5	Яамны алба хаагчдад Монгол бичгийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Алба хаагчид 2025 оны ГТ-нд Монгол бичгийг бие даан сурахаар төлөвлөсөн.	Хагас жилийн байдлаар: -Монгол бичгийн сургалт зохион байгуулах 2026 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Төлөвлөгөөний дагуу сургалтад яамны 82 алба хаагч хамрагдсан байна.	I-IV улирал	ТЗУГ
2.6	Гадаадын цэргийн их, дээд сургууль төгсөгч нартай "Дадлагажуулах нэмэлт сургалт"-ыг зохион байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Хамрагдсан алба хаагчдын тоо	Гадаадын цэргийн их, дээд сургуульд 450 гаруй ЦАХ суралцаж байна.	Хагас жилийн байдлаар: Сургалт зохион байгуулан явуулах хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах зардлын тооцоог боловсруулна. Жилийн эцсийн байдлаар: "Дадлагажуулах нэмэлт сургалт"-ад 40 доошгүй алба хаагчдыг хамруулж, дадлагажуулсан байна.	III улирал	ТЗУГ, ЗХЖШ
2.7	Алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Хамрагдсан алба хаагчдын тоо	Орон сууц, хашаа байшин худалдаж авах төлбөрт зориулж 105 алба хаагчид буцалтгүй тусламж олгосон.	Хагас жилийн байдлаар: Ипотекийн зээлд дараалалгүйгээр 50 алба хаагч хамруулсан байна; Жилийн эцсийн байдлаар: Жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бичил бизнес эрхэлдэг 20 доошгүй алба хаагчдын гэр бүлд хөнгөлөлттэй зээл тусламж үзүүлсэн байна.	I-IV улирал	ТЗУГ, БХЗГ
2.8	Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний үүсэн байгуулагдсаны 105 жилийн ой, Батлан хамгаалах яамны 115 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	Зэвсэгт хүчний 100 жилийн ой, Батлан хамгаалах яамны 110 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн.	Хагас жилийн байдлаар: Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг байгуулж, Зэвсэгт хүчний 105 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Батлан хамгаалах яамны 115 жилийн ойн төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг батлуулсан байна.	I-IV улирал	ТЗУГ

1	2	3	4	5	6	7	8
					Жилийн эцсийн байдлаар: Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.		
2.9	Тулгар төрийн 2235 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 820 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 115 жил, Ардын хувьсгалын 105 жилийн ой, Төрийн далбааны өдрийг тохиолдуулан зохион байгуулагдах техниктэй "Цэргийн ёслолын жагсаал"-ыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Ардын хувьсгалын 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлсэн.	Хагас жилийн байдлаар: Ойг тэмдэглэн өнгөрүүлэх төсөв, тооцоог судалгааг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. - Ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөг батлуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	I-IV улирал	ТЗУГ, ЗХЖШ, яамны харьяа байгууллагууд
2.10	Монгол хүн сансарт ниссэний болон сансрын хамтарсан нислэгийн 45 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх	Засгийн газраас баталсан төсвийн дагуу	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЗГ-ын 2019 оны 204 дүгээр тогтоолын дагуу 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.	Хагас жилийн байдлаар: - Ойг тэмдэглэн өнгөрүүлэх төсөв, тооцоог судалгааг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. - Ойг тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө боловсруулна; Жилийн эцсийн байдлаар: - Ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	I-II улирал	ТЗУГ, ЗХЖШ, АЦК
2.11	Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагааг сурталчлах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулах	30.0 сая ₮, ЗХХС	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Орон нутагт 2 удаа зохион байгуулсан.	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулсан байна. - 5 удаагийн үзэсгэлэн гаргах, Архивын лавлагаа, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулж, иргэд, олон нийтэд батлан хамгаалах бодлого, үйл	I-IV улирал	ТЗУГ, ЗХЖШ, яамны харьяа байгууллагууд

1	2	3	4	5	6	7	8
					ажиллагааг сурталчилсан байна.		
2.12	Төрийн цэргийн байгууллагуудын дунд “Эх оронч Монгол” сэдэвт видео контентын төсөл хэрэгжүүлэх	ЗХХС	Төслийн хэрэгжилт	Удирдамж боловсруулсан.	Хагас жилийн байдлаар: Батлан хамгаалах, Төрийн цэргийн байгууллагуудад удирдамжийг хүргүүлнэ. -Төслийг I, II шатыг зохион байгуулан явуулж, шилдэг 3 байрны видео контентыг шалгаруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: Хүүхэд залууст эх оронч үзэл хүмүүжил олгох видео контент бэлтгэгдэж, ТВ, болон олон нийтийн сүлжээгээр сурталчилсан байна.	I-IV улирал	ТЗУГ, Соёмбо редакц
2.13	“Тэмүүжин өрлөг” бүрэн дунд сургуульд төрөлжсөн сургалттай анги байгуулах саналыг боловсруулах	-	Боловсруулсан саналын тоо	Төсөл боловсруулагдсан.	Хагас жилийн байдлаар: -“Тэмүүжин өрлөг” бүрэн дунд сургуульд төрөлжсөн сургалттай анги байгуулах санал, тооцоог боловсруулж, яамны удирдлагад танилцуулна.	I-IV улирал	СБТГ, ҮБХИС
ЗОРИЛТ 3. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГЛЭЛ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТ, БАТЛАН ХАМГААЛАХ МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙГ ҮЕ ШАТТАЙГААР БҮРДҮҮЛЖ, УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
3.1	Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Техник, хэрэгслээр нөхөн хангах тоо Худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн тоо	2025 онд 117 нэгж туулах чадвар сайтай, тусгай тоноглолтой автотехникээр нөхөн хангасан.	Хагас жилийн байдлаар: Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулна. Жилийн эцсийн байдлаар: Зэвсэгт хүчинд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авсан байна.	I-IV улирал	БХЗГ
3.2	Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудын	17,709.8 УТХО	Техник, хэрэгслээр нөхөн хангах тоо	Цэргийн багт 14 нэгж техник хүлээлгэн өгч, галт	Хагас жилийн байдлаар: Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан	I-IV улирал	БХЗГ

1	2	3	4	5	6	7	8
	зэвсэглэл, техникийг шинэчлэх		Худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн тоо	хэрэглэлийг нийлүүлсэн.	байгууллагуудтай гэрээ байгуулна. Жилийн эцсийн байдлаар: Цэргийн багуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авсан байна.		
3.3	"Тэрбум мод" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	Холбогдох эх үүсвэрийн хүрээнд	Төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь /Модны төрөл, тоо/	31 нэр төрлийн 1,544,154 ширхэг модыг суулгацаар, 16 нэр төрлийн 278.4 кг үрээр тарьж ургуулсан.	Хагас жилийн байдлаар: -Мод тарих бэлтгэл ажлыг хангуулж, хэрэгжилтийг 20 хувьд хүргэнэ; -Хаврын мод тарилтыг суулгацаар 500,000 ширхэг мод тарьж, ургуулна. Жилийн эцсийн байдлаар: -Намрын мод тарилтыг суулгацаар 500,000 ширхэг мод тарьж, ургуулна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ.	I-IV улирал	БХЗГ
3.4	Зэвсэг, галт хэрэглэлийн үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, урсгал хэрэгцээний галт хэрэглэлийн нөөц бүрдүүлэх, сумны бэлдэц болон бэлдэц үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах	6,6 тэрбум төгрөг УТХО	Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо	Сумны үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлж 3 нэр төрлийн сум үйлдвэрлэдэг болсон.	Хагас жилийн байдлаар: Сумны бэлдэц үйлдвэрлэх тоног төхөөрөмж, бэлдцийн үнийн судалгаа хийнэ. Жилийн эцсийн байдлаар: - Бэлдцийн үйлдвэрээс бэлдэц авах талаар гэрээ, хэлэлцээрийг хийх бэлтгэл ажлыг хангасан байна; - Сумны бэлдэц худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангана.	I-IV улирал	БХЗГ
3.5	Зэвсэгт хүчний Агаарын цэргийн зэвсэглэл, техникийг шинэчилж, засварлах	13,2 тэрбум төгрөг	Шинэчилж засварласан техникийн тоо	2025 онд 1 нэгж нисдэг тэрэгний засварын ажил, тоон системийн радиолокацын станц П-12СМ"	Хагас жилийн байдлаар: - Ми-171Е загварын 1 нэгж нисдэг тэргийг их засварт оруулах гэрээг хийж, их засварт оруулна	I-IV улирал	БХЗГ

1	2	3	4	5	6	7	8
				төслийн I шатыг хэрэгжүүлсэн.	- Тоон системийн П-12СМ төслийн II шатанд шаардлагатай тооцоог гаргаж, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг зохион байгуулна. Жилийн эцсийн байдлаар: - Ми-171Е загварын МТ-1001 дугаартай 1 нэгж нисдэг тэргийг их засвараас хүлээн авна. -Тоон системийн П-12СМ төслийн II шатны тоног төхөөрөмжийг хүлээн авч, ашиглалтад оруулна.		
3.6	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж дрон, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт техник, хэрэгслийг худалдан авах, дотооддоо зохион бүтээж, турших	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94 нэр төрлийн орчин үеийн ННХ худалдан авсан. Цэргийн зориулалттай 5 ННХ зохион бүтээж, туршсан.	Хагас жилийн байдлаар: -Ажлын зургийн дагуу дроны сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх үйлдвэрийн ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан байна; - Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулна. Жилийн эцсийн байдлаар: -Дрон угсарч, үйлдвэрлэх үйлдвэрийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь хангасан байна. Техник хэрэгслийг худалдан авч, ... зохион бүтээж туршсан байна.	I-IV улирал	БХЗГ
3.7	Зэвсэг техник, материал хэрэгслийг гадаадын зээл, тусламжаар шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх	-	Цэрэг техникийн буцалтгүй тусламж үзүүлсэн гадаад улсын тоо	5 улсаас зээл тусламж, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.	Хагас жилийн байдлаар: 1 улсаас буцалтгүй тусламжийн төсөл, арга хэмжээг эхлүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар:	I-IV улирал	БХЗГ

1	2	3	4	5	6	7	8
					1 улсаас буцалтгүй тусламжийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.		
3.8	Монгол Улс, БНСВУ-ын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх хүрээнд хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж бараа бүтээгдэхүүн харилцан нийлүүлэх боломжийг бүрдүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Гүйцэтгэлийн хувь	2 улсын Батлан хамгаалахын сайдын уулзалтаар хамтран ажиллах талаар санал солилцсон.	Хагас жилийн байдлаар: -Холбогдох тооцоо, судалгааг гаргасан байна. - Бүтээгдэхүүн солилцох ажлын хүрээнд холбогдох тушаал, шийдвэрийг гаргаж, гэрээ байгуулна. Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тооцоо судлагаа хийж, холбогдох тушаал шийдвэрийг гаргуулж, гэрээ байгуулна. Жилийн эцсийн байдлаар: -Гэрээний хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ.	I-IV улирал	БХЗГ
3.9	Зэвсэгт хүчний анги, байгууллагын сургалтын орчин, материаллаг баазыг үе шаттайгаар сайжруулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Техник хэрэгсэл хуваарилсан ангийн тоо	Зэвсэгт хүчний 4 ангид цахим анги шинээр тохижуулж, 22 ангийг 420 иж компьютероор хангасан.	Хагас жилийн байдлаар: Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулна. Жилийн эцсийн байдлаар: -Анги, байгууллага, салбарын албан хэрэгцээнд зориулж том оврын автомашин, компьютер, техник хэрэгслээр 5 ангийг хангасан байна. Зэвсэгт хүчний 5 ангийн сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.	I-IV улирал	БХЗГ
3.10	Батлан хамгаалах материаллаг нөөцийг сольж шинэчлэх, материаллаг нөөцийн хэмжээг шинэчлэн батлуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Нөөцийн хангалтын хувь	Шатахуун 100 хувь Хүнс 80 хувь	Хагас жилийн байдлаар: Материаллаг нөөцийн хэмжээг шинэчлэн батлуулах саналыг Засгийн газрын хуралдаанд оруулсан байна. Жилийн эцсийн байдлаар:	I-IV улирал	БХЗГ

1	2	3	4	5	6	7	8
					Холбогдох тооцоо, судалгааг гаргаж, нөөцийн хүнсийг 100 хувь хангасан байна.		
3.11	Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд шинээр хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Хэрэгжилтийн хувь Гүйцэтгэлийн хувь	21 төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажилд Улсын комисс ажилласан.	Хагас жилийн байдлаар: -Холбогдох тооцоо, судалгааг хийж, худалдан авах ажиллагааг зохион байгуулна. Жилийн эцсийн байдлаар: -УТХО, ЗХХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	I-IV улирал	БХЗГ
3.12	Улсын батлан хамгаалах тусгай хэрэгцээний газрын асуудлыг шийдвэрлүүлэх	Төсөв шаардахгүй	Боловсруулсан албан бичгийн тоо	35 албан бичиг хүргүүлсэн.	Хагас жилийн байдлаар: Холбогдох саналын төслийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: Улсын батлан хамгаалах тусгай хэрэгцээний газрын асуудлыг шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагад 35 санал хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна.	I-IV улирал	БХЗГ
ЗОРИЛТ 4. БАТЛАН ХАМГААЛАХЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН СУРГАЛТ, ХАМТАРСАН СУРГУУЛЬ, ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.							
4.1	Батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх	-	Хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн орны тоо	Хамтын ажиллагаатай орны тоо 1-ээр нэмэгдсэн.	Хагас жилийн байдлаар: -Хамтын ажиллагаатай орны тоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: -Хамтын ажиллагаатай орны тоог 1-ээр нэмэгдүүлнэ.	I-IV улирал	ГХАГ
4.2	Батлан хамгаалах салбарын бүх түвшний	1,200.0 сая ₮, ЗХХС	Харилцан айлчлалын тоо	21 удаагийн бүх түвшний харилцан айлчлал хэрэгжсэн.	Хагас жилийн байдлаар: -10 удаагийн харилцан айлчлал хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ГХАГ

1	2	3	4	5	6	7	8
	харилцан айлчлалыг хэрэгжүүлэх				Жилийн эцсийн байдлаар: -20 удаагийн харилцан айлчлал хэрэгжүүлнэ.		
4.3	Гадаад улсын Батлан хамгаалах яамтай зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалтуудыг зохион байгуулах.	400.0 сая ₮ ЗХХС	Зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалтуудын тоо	10 удаагийн зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалт хэрэгжсэн.	Хагас жилийн байдлаар: - 4 зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалтыг хэрэгжүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: - 10 зөвлөлдөх болон ажлын хэсгийн уулзалтыг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	ГХАГ
4.4	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг олон улсын болон хоёр талын хамтарсан сургалт, дадлагад оролцуулах	-	Оролцсон сургалт, дадлагын тоо	12 сургалт, дадлагад оролцсон	Хагас жилийн байдлаар: - 5 хамтарсан сургалт, дадлага зохион байгуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: - 10 хамтарсан сургалт, дадлага зохион байгуулсан байна.	I-IV улирал	СБТГ, ГХАГ, ЗХЖШ,
4.5	Хамтын ажиллагаатай улс орнуудад сургалт зохион байгуулж явуулах	250.0 сая ₮ ЗХХС	Явуулсан сургалтын тоо	БНКУ-д Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан.	Хагас жилийн байдлаар: - Сургалт зохион байгуулах зохион байгуулах талаар холбогдох гэрээ хэлцлийг байгуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: - 2 сургалт зохион байгуулна.	I-IV улирал	ЗХЖШ, ГХАГ
4.6	НҮБ-тай хамтран хэрэгжүүлэх "Энхийг сахиулагчид, тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх жишиг хөтөлбөр"-ийг сурталчлах	Батлагдсан төсвийн хүрээнд	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 арга хэмжээ зохион байгуулсан	Хагас жилийн байдлаар: - Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэлийг хангана. Жилийн эцсийн байдлаар: - 2 доошгүй арга хэмжээ зохион байгуулна.	I-IV улирал	ГХАГ, ЗХЖШ
4.7	"2027 оны Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг, цэргийн алба хаагчийг оролцуулах болон олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион	-	Тогтоол, тушаалын тоо	Засгийн газрын тогтоол 1, сайдын тушаал 1 боловсруулсан	Жилийн эцсийн байдлаар: -Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, яамдаас санал авна; -"2027 онд энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг, цэргийн алба хаагчийг	III-IV улирал	СБТГ, ЗХЖШ

1	2	3	4	5	6	7	8
	байгуулах тухай” шийдвэр гаргуулах				оролцуулах болон олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах тухай” асуудлыг Засгийн газарт хүргүүлж, шийдвэр гаргуулна; -Батлан хамгаалахын сайдын тушаалын төслийг боловсруулна.		
ЗОРИЛТ 5. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ, УЛСЫН ДАЙЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУИ БОЛГОЖ, ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧИЛАХ, ИРГЭДИЙН ЭХ ОРНОО ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.							
5.1	Хугацаат цэргийн алба хаагчийг аймаг, орон нутагтаа эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр суралцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, сургалт зохион байгуулах	497 сая ₮ ХЭДС	Мэргэжил эзэмшсэн ХЦАХ- ын тоо	270	Хагас жилийн байдлаар: - ХЦАХ-дад мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг батлуулна; - Сургалтад алба хаагчдыг хамруулж эхлүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: -1000 ХЦАХ-ийг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулсан байна.	I-IV	СБТГ, ЗХЖШ-ын СБГ
5.2	“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах	5.58 тэрбум ₮ Улсын төсвөөс	Сургалтад хамрагдсан оюутан, суралцагчийн тоо	“Оюутан-цэрэг” сургалтад 1997 оюутан хамрагдсан.	Хагас жилийн байдлаар: -“Оюутан-цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулах тухай”, “Сургалтад хамруулах тухай” Батлан хамгаалахын сайдын тушаалыг тус тус батлуулсан байна. -Сургалтын бүртгэл, сонгон шалгаруулалтыг явуулж, “Цэргийн ерөнхий бэлтгэл шат”-ны онолын сургалтыг зохион байгуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулж, Батлан хамгаалахын	I-III улирал	ОНХДГ, ЗХЖШ, Цэргийн штабууд

1	2	3	4	5	6	7	8
					сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан байна.		
5.3	“Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль”-ийг зохион байгуулах	541,0 сая төгрөг Орон нутгийн төсвөөс	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	“Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль явуулах тухай” ЗГ-ын тогтоол гарсан.	Хагас жилийн байдлаар: -Нэгдсэн сургуулийн холбогдох удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулсан байна. -Нэгдсэн сургууль явуулах газар орон, 3 аймгийн бэлтгэл ажлыг хангуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг зохион байгуулж явуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. -2027 онд “Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль”-ийг явуулах тухай асуудлыг ЗГХЭГ-т хүргүүлнэ.	I-III улирал	ОНХДГ
5.4	Аймаг, нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулах Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний цугларалт, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг зохион байгуулах	Аймаг, нийслэлийн төсвөөс	Зохион байгуулсан сургалтын тоо	2025 онд 8 аймаг, 3 дүүрэгт сургалт зохион байгуулсан.	Хагас жилийн байдлаар: 8 аймаг, 4 дүүрэгт Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний цугларалт, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалт зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, тусалцаа үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна. -Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын оролцоог нэмэгдүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар: 2 аймаг, 2 дүүрэгт Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний цугларалт, Орон нутгийн хамгаалалтын	I-IV улирал	ОНХДГ, Цэргийн штабууд

1	2	3	4	5	6	7	8
					томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалт зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж, удирдлагаар ханган ажилласан байна.		
5.5	Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг 2026 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих, дүгнэх	-	Байгуулагдсан гэрээний тоо, гэрээний хэрэгжилтийг хувь	Аймаг, нийслэлийн Засаг даргатай 22 гэрээ байгуулагдсан.	Хагас жилийн байдлаар: -Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 22 гэрээг байгуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 22 гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, тайланг ЗГХЭГ-т хүргүүлнэ.	I, IV улирал	ОНХДГ, ХШУДАХ
5.6	Төрийн захиргааны төв байгууллагын харьяа төрийн байгууллага, баг, хорооны болон сум, дүүргийн нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний дайчилгааны даалгаврыг тогтоож, Дайчилгааны төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн сургалт зохион байгуулж, удирдлагаар хангах	-	Зөвлөмжийн тоо, зохион байгуулсан сургалтын тоо	Аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг Засгийн газрын тогтоолоор батлуулж, 96 төрийн байгууллага, 330 сум, 9 дүүргийн дайчилгааны даалгавар болон дайчилгааны төлөвлөгөөг батлуулсан.	Хагас жилийн байдлаар: - “Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах тухай” Батлан хамгаалахын сайдын тушаал гаргуулсан байна. - 2 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар: - Дайчилгааны төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх 10 доошгүй сургалтыг зохион байгуулсан байна.	I-IV улирал	ОНХДГ
5.7	2026 онд явагдах Зэвсэгт хүчний ... дугаар ангитай явуулах дайчилгаатай	792,0 сая ₮ Улсын төсвөөс	Дайчилгаатай сургууль явуулсан хэрэгжилтийн хувь, үнэлгээ	2025 онд Засгийн газрын тогтоол 1, Батлан хамгаалахын	Хагас жилийн байдлаар: “Зэвсэгт хүчний ... дугаар ангитай явуулах дайчилгаатай	II-III улирал	ОНХДГ, СБТГ, БХЗГ, ХШУДАХ

1	2	3	4	5	6	7	8
	сургуулийн явцад хяналт тавих			сайдын тушаал 1 батлагдсан.	сургууль явуулах тухай" БХС-ын тушаал гаргуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: Дайчилгаатай сургуульд хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.		
5.8	Сумын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт, цэргийн чухал мэргэжлийн офицер бэлтгэх бэлтгэл офицерын сургалт, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулахад хяналт тавих	150,0 сая төгрөг Улсын төсвөөс	Батлагдсан эрх зүйн баримтын тоо, зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай "Цэрэг-стратегийн бэлтгэл" сургалтыг, 330 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг, цэргийн чухал мэргэжлийн офицер бэлтгэх сургалтыг, нэгдүгээр зэргийн 405 бэлтгэл үүрэгтний сургалтыг тус тус зохион байгуулсан.	Хагас жилийн байдлаар: -"Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах тухай" БХС-ын тушаал батлуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: -Сумын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулахад хяналт тавьж, мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна. -Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад "Нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт", ҮБХИС-д "Цэргийн чухал мэргэжлийн бэлтгэл офицерын сургалт"-ыг тус тус зохион байгуулахад хяналт тавьж, мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	I-IV улирал	ОНХДГ, Цэргийн штабууд
